

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2021

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО · 2030 БА МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН УЯЛДАА, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Б.Ананд¹, Э.Хосбаяр²

<i>JEL ангилал:</i> L52, O10, O20	<i>Хураангуй:</i> Энэхүү өгүүллээр Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан Тогтвортой хөгжлийн зорилго · 2030 (ТХЗ-2030) бодлогын баримт бичгийн хүрээнд дэлхий нийтээр дэвшүүлсэн нэн тэргүүний зорилтууд, голлох эдийн засгийн цаашид авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын ТХЗ-2030-тай уялдаж буй байдал болон энэ хүрээнд анхаарах асуудлын талаар авч үзлээ.
<i>Түлхүүр үг:</i> Тогтвортой хөгжил, хөгжлийн бодлого	

1. Удиртгал

Дэлхийн нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий хэмжээ аж үйлдвэрлэлийн нэгдүгээр хувьсгалаас хойш буюу 1750 оноос XXI зууны эхэн үе хүртэл 50 дахин нэмэгдсэн ба жилийн дундаж өсөлт нь 1.5 хувь байсан гэж үздэг (Английн Төв банк, 2020). Эдийн засгийн өсөлтийн цаана үйлдвэрлэл, технологийн дэвшил хурдацтай явагдаж, түүхий эд, байгалийн баялгийн нөөцийг үлэмж хэмжээгээр ашиглах болсноор үүнийг дагасан нийгэм, эдийн засгийн зардал улам бүр өсөн нэмэгдсэн (Нэгдсэн Үндэстний Байгууллага, 2015). Жишээлбэл, Дэлхийн банкны мэдээллээс үзэхэд, дэлхийн нэрлэсэн ДНБ сүүлийн 50 жилд буюу 1970-2020 онд 28.4 дахин нэмэгдсэн бол хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ 27.1 тэрбум тонн (CO₂-экв)-оос 45.9 тэрбум тонн болж 1.7 дахин нэмэгдсэн, 2019 оны байдлаар дэлхийн дундаж температур 1961-1990 оны дунджаас 0.8 хэмээр нэмэгдсэн байна. Ядуурал, ажилгүйдэл, тэгш бус байдал зэрэг нийгэм эдийн засгийн үндсэн үзүүлэлт дэлхийн түвшинд буурч байгаа ч улс орнуудын бүтээмжийн ялгаа, улс доторх орлогын тэгш бус хуваарилалтаас үүдэн ядуурал, тэгш бус байдал, ажилгүйдэл эрс нэмэгдсэн нь НҮБ, түүний гишүүн орнуудын нэн тэргүүнд анхааралдаа авах асуудал болоод байна.

Дэлхий дахинд хурдацтай өрнөж буй хөгжил дэвшлээс үүдсэн нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлыг шийдэх, дэлхийн хүн амын тав тухтай,

¹ Монголбанкны Судалгаа, статистикийн газрын Судалгааны хэлтсийн ахлах эдийн засагч.
Цахим шуудан: anand.b@mongolbank.mn

² Монголбанкны Судалгаа, статистикийн газрын Судалгааны хэлтсийн эдийн засагч.
Цахим шуудан: khosbayar.e@mongolbank.mn

тогтвортой амьдралын хэв маягийг бий болгох зорилгоор НҮБ, дэлхийн 193 улсын санаачилгаар Мянганы хөгжлийн зорилтын залгамж болгон Тогтвортой хөгжлийн зорилго-2030 (цаашид ТХЗ-2030 гэх) дэлхий нийтийн урт хугацааны бодлогын баримт бичгийг 2015 онд баталсан билээ. Энэхүү баримт бичигт 17 ерөнхий зорилгын хүрээнд 169 зорилтыг дэвшүүлэн улс орон бүр өөрсдийн урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлж эхлээд байна.

Манай орны хувьд Мянганы хөгжлийн зорилтод суурилсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Тогтвортой хөгжлийн зорилгод суурилсан “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2016-2030” зэрэг бодлогын баримт бичгийг боловсруулж байсан бол 2020 онд “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг боловсруулан Улсын Их Хурлаар баталсан нь ТХЗ-2030 баримт бичигтэй уялдан хэрэгжиж буй урт хугацааны нэгдсэн бодлогын баримт бичиг болоод байна.

2. Тогтвортой хөгжлийн зорилго · 2030

2016 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн ТХЗ-2030 урт хугацааны бодлогын баримт бичгийг анх 2012 оны Рио-де-Жанейро хотод болсон НҮБ-ийн гишүүн орнуудын төр, засгийн тэргүүн оролцсон “Тогтвортой хөгжил” сэдэвт бага хурлын үеэр санаачилж НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар 17 зорилго, 169 зорилтын хамт 2015 онд баталжээ. Нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн үндсэн гурван чиглэлд хамаарах 17 зорилгыг 2030 он хүртэл авч хэрэгжүүлэхээр тусгасан ба нийт 169 зорилтыг дэвшүүлжээ. ТХЗ-2030-ын хүрээнд улс орон бүр өөрийн онцлог, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхээр тогтсон бөгөөд ТХЗ-ийн дагуу хэрэгжүүлж буй зорилгын биелэлт, ахиц дэвшлийг улс орон бүр Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (National Determined Contribution), Үндэсний сайн дурын илтгэл (Voluntary National Review) гэсэн голлох баримт бичгийн дагуу тайлагнадаг байна.


НҮБ-ын зүгээс ТХЗ-2030-ын хүрээнд дэвшүүлсэн 17 зорилгоос уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай алхам гэж зарласан. Учир нь өнгөрөгч арван жил дэлхийн түүхэнд хамгийн өндөр температуртай мөчлөг болж, дэлхий нийтээр байгалийн гамшигт үзэгдлийн давтамж илүү ойртож, үүнийг дагасан эдийн засаг, нийгмийн зардал илүү ихээр нэмэгдэж байгаа юм. Австрали улсад гарсан түймэр, Индонезийн Жакарта хотын үер, Лос Анжелес хотын түймэр, Дели хот түүхэн дэх хамгийн өндөр температурыг бүртгэсэн зэрэг хамгийн сүүлд болсон үзэгдлийг дурдаж болно. Иймд НҮБ-ын зүгээс ТХЗ-2030-ын хүрээнд дэлхийн хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 50 хувиар бууруулах эрчимжүүлсэн зорилтыг тавиад байгаа бөгөөд энэхүү зорилтод хүрэхийн тулд улс орны Засгийн газрыг сэргээгдэхгүй эрчим хүчний салбарт татаас өгөхөө зогсоох, татварын дарамтыг

иргэд, аж ахуйн нэгжийн орлогын татвараас илүүтэйгээр нүүрс, нүүрстөрөгчийн хийн чиглэлд хандуулахыг зөвлөсөн ба ингэснээр ажил эрхлэлт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ач холбогдолтой гэж үзсэн ажээ.

2.1. Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг Парисын хэлэлцээр

Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэлхий нийтээр авч хэрэгжүүлж буй өөр нэгэн бодлогын баримт бичиг нь Парисын хэлэлцээр юм. Парисын хэлэлцээр нь улс орнуудын нэгдмэл зөвшилцлийн дагуу дэлхийн 197 улс 2015 онд байгуулсан хууль ёсны эрх зүйн баримт бичиг ба үндсэн зорилго нь дэлхийн дулаарлыг аж үйлдвэржилтийн өмнөх үеийн температуртай харьцуулахад 2 хэмээс доош буюу 1.5 хэмд барих зорилготой, таван жилийн мөчлөгтэй зорилтуудыг багтаасан хэлэлцээр юм. Үүний хүрээнд эдийн засаг, нийгмийн чиглэлээр эрчимтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Зураг 1



Эх сурвалж: Дэлхийн банк, судлаачийн тооцоолол

2.2. Одоогийн 5 жилийн зорилтууд


1. Улс орнууд дэлхийн дулаарлыг бууруулах зорилтод хүрэхийн тулд хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг бууруулах. Энэ ажлын биелэлтийг 2020 оны эцэст “Улс орнууд өөрсдийн санаачилгаар гаргадаг амлалт бичгийн төсөл” (Intended Nationally Determined Contribution)-өөр дамжуулан тайлагнах;

2. Өндөр температуртай орчин нөхцөлд зохицсон амьдрах орчныг бий болгоход чиглэсэн бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, санхүүгийн урсгалыг дэмжих;

3. 2024 оноос эхлэн уур амьсгалын эсрэг авсан бодлогын арга хэмжээг шилэн байдлаар тайлагнадаг болох зэрэг зорилтыг тавин ажиллаж байна.


Зураг 2

Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээний нийт эрчим хүчний хэрэглээнд эзлэх хувь



Зураг 3

Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр авч буй гадаад санхүүжилт



Эх сурвалж: International Energy Agency and UN Statistics Division

3. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлт

Манай орон “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал” (1996), “Монгол Улсын XXI зууны Тогтвортой хөгжлийн хөтөлбөр” (1998), Мянганы хөгжлийн зорилтод суурилсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого” (2008) зэрэг дунд болон урт хугацааны нийгэм, эдийн засгийн асуудлыг багтаасан хөгжлийн хөтөлбөр, бодлогын баримт бичгийг боловсруулж байсан ажээ.

Зураг 4

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүд				
2008-2021	2014-2030	2016-2030	2020-2050	2020.05.07
Үндэсний хөгжлийн цогц бодлого	Ногоон хөгжлийн бодлого	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал	Алсын хараа 2050	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эдгээр хөгжлийн бодлогын баримт бичгээс ТХЗ-2030-тай уялдаа бүхий Ногоон хөгжлийн бодлого, Алсын хараа-2050 зэрэг баримт бичиг нь хэрэгжилтийн шатанд явж байна (Зураг 4). Харин Үндэсний хөгжлийн цогц

бодлогын хувьд Мянганы хөгжлийн зорилгод нийцүүлэн боловсруулж байсан ба 2015 онд Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийн хугацаа дуусгавар болсон бол 2016 онд батлагдсан “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал · 2030” нь агуулгын хувьд “Алсын хараа 2050”-д багтсан гэж үзэн 2020 онд хүчингүй болгосон байна. Түүнчлэн Монгол Улс хөгжлийн бодлогыг тодорхойлох баримт бичгийн зарчим, хэрэгжилт, үнэлгээ, оновчтой тогтолцоог бүрдүүлэх, төлөвлөлт оролцогч талуудын эрх, үүргийг зохицуулах зорилгоор “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 онд баталсан ажээ.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал · 2030 (2016.02.05 өдөр баталсан): Монгол Улс тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үндсэн зорилго нь “Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоор дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно” гэсэн байна. ТХҮБ нь: 1) Эдийн засгийн тогтвортой хөгжил; 2) Нийгмийн тогтвортой хөгжил; 3) Байгаль орчны тогтвортой хөгжил; 4) Тогтвортой хөгжлийн засаглал гэсэн үндсэн дөрвөн агуулгын хүрээнд 10 зорилгыг дэвшүүлжээ. Түүнчлэн, Үндэсний хөгжлийн газрын үнэлгээнд Монгол Улсын ТХҮБ 2030 баримт бичгийг ТХЗ-2030-д тулгуурлан боловсруулсан ч түүний 50-60 хувь нь л тусгагдсан гэжээ [1].

Ногоон хөгжлийн бодлого 2030: НҮБ-ийн 2012 оны тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалтаар уур амьсгалын өөрчлөлт, хүн амын хурдацтай өсөлт, хэрэглээ зэрэг нь нөөцийн хомсдолд асар хурдацтай хөтөлж байгаа тул улс орон бүр өөрийн онцлогт тохирсон ногоон эдийн засаг, ногоон хөгжлийн бодлогыг боловсруулан мөрдөж ажиллах нь зүйтэй гэж зөвлөсний дагуу Монгол Улс “Ногоон хөгжлийн бодлого”-ыг 2014 онд баталсан бөгөөд хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох агуулгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлжээ.

Хүснэгт 1

“Ногоон хөгжлийн бодлого 2030”-ын шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт (хувиар)	2020	2030
1.	Эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь	20	30
2.	Барилгын дулааны алдагдлын бууралт, хувь	20	40
3.	Хог хаягдлын дахин боловсруулалтын хэмжээ, хувь	20	40
4.	Ногоон хөгжилд зарцуулах зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2	3
5.	Шинжлэх ухаан, технологийн судалгаанд зарцуулах зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2	3

6.	Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь	20	30
7.	Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ, хувь	25	30
8.	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хувь	20	30
9.	Нийт газар нутагт ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	8.5	9
10.	Баталгаат ундны усаар хангагдах хүн амын эзлэх хувь	80	90
11.	Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдах хүн амын эзлэх хувь	40	60
12.	Ядуурлын түвшин	24	15
13.	Улаанбаатар хот, бусад суурин газрын ногоон байгууламжийн талбайн эзлэх хувь	15	30
14.	Дотоодын нийт бүтээгдэхүүнд хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь	28	30

Эх сурвалж: www.legalinfo.mn

Зорилтод хүрэх хугацааг 2020 он болон 2030 он гэсэн хоёр үе шаттайгаар баримт бичигт тусгасан байна.



Алсын хараа 2050. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (2020.05.13 өдөр баталсан): 2021 оны байдлаар хэрэгжих шатанд байгаа

улсын хэмжээний, урт хугацааны, нэгдсэн хөгжлийн бодлогын баримт бичиг нь 2020 онд батлагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг юм. Энэхүү баримт бичиг нь 1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”; 2. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн

бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”; 3. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдэх ба шалгуур үзүүлэлтийн дагуу үр дүнг үнэлж, таван жил тутамд УИХ-д танилцуулна. Алсын хараа-2050-ийн хүрээнд нийгэм, эдийн засаг, хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх агуулгын хүрээнд нийт 9 зорилгыг дэвшүүлсэн байна (Зураг 5).


3.1. ТХЗ-2030 болон Алсын хараа-2050 баримт бичгүүдийн уялдаа

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох Алсын хараа 2050-д ТХЗ 2030-тай шууд уялдсан **26 зорилт тусгагджээ** (Зураг 6-д Алсын хараа 2050-д тусгагдсан зорилтын дугаарыг тэмдэглэв). Алсын хараа 2050-ын үндсэн 9 зорилгын хүрээнд дэвшүүлсэн дэд зорилтоос Хүний хөгжлийн

зорилгын 5 зорилт, Ногоон хөгжлийн зорилгын 4 зорилт, Улаанбаатар ба дагуул хот зорилгын 4 зорилт ТХЗ 2030-ын 17 зорилготой шууд уялдсан байна (Зураг 5). Өөрөөр хэлбэл, эдгээр зорилгуудын хувьд НҮБ-ийн ТХЗ-2030-тай нийцтэй байдал хамгийн өндөр байгаа бол Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Засаглал, Амар тайван аюулгүй нийгэм зэрэг зорилгын хувьд ТХЗ 2030-ын үндсэн зорилгуудтай шууд хамаарал бага байна.

Зураг 6

ТХЗ 2030 болон Алсын хараа 2050-ын зорилтуудын шууд уялдаа




Эх сурвалж: НҮБ, УСХ, Судлаачийн тооцоолол

ТХЗ-2030-ын хүрээнд Монгол Улсын дэвшүүлсэн нэн тэргүүний зорилгууд дунд хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 2010 оны суурь түвшнээс 22.7 хувиар бууруулахаар тусгасан. Түүнчлэн, “Алсын хараа 2050” бодлогын баримт бичгийн 6 дугаар зорилго буюу Ногоон хөгжил бүлэгт: “6.4.7. Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлж, Монгол Улсын тодорхойлсон хувь нэмэр (NDC)

баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэн, эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна” гэж тусгажээ. Харин Монгол Улсын хүлэмжийн хий ялгаруулалтын хэмжээ 1990 онтой харьцуулахад 2020 онд 75 хувиар нэмэгдсэн байна (Зураг 1). Харин Европын холбооны улсууд, Япон, Казакстан зэрэг улсын хүлэмжийн хий ялгаруулалтын хэмжээ 1990 оны түвшнээс буурсан байна.

Монгол Улсын ТХЗ 2030-тай уялдаж буй өөр нэгэн бодлогын баримт бичиг нь 2014 онд УИХ-аар батлагдсан Ногоон хөгжлийн бодлого юм. Энэхүү баримт бичигт уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарал зэрэг нийгэм, эдийн засгийн хөгжлөөс үүдэн гарсан сөрөг нөлөөллийг бууруулах заалтууд тусгагдсан. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад улс орон бүр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад оруулах хувь нэмрээ тодорхойлсон байна.

Зураг 7




Эх сурвалж: НҮБ

Алсын хараа 2050 баримт бичигт: “Монгол Улсын хувьд Үндэсний тодорхойлсон хувь нэмэр”-ээ Ногоон хөгжлийн бодлого, Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрт тулгуурлан боловсруулсан бөгөөд эрчим хүч, барилга, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, хог хаягдлын салбарт хэрэгжүүлэх байгальд ээлтэй ногоон бодлого, арга хэмжээний үр дүнд эдийн засгийн хөгжил өнөөгийн хандлагаар явна гэсэн төсөөлөлтэй харьцуулахад 2030 он гэхэд хүлэмжийн хийн нийт ялгарал 22.7 хувиар буурахаар байна. Эдгээр хувь нэмрээ биелүүлэхэд Конвенцын хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн механизм,

арга хэрэгслээр дамжуулан шинэ технологи нэвтрүүлэх, санхүүгийн дэмжлэг авах боломж, нөхцөл хэр байхаас ихээхэн хамаарах юм” хэмээжээ.

4. Олон улсад хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бодлогын алхмууд

Монгол Улсын эдийн засаг уул уурхайн түүхий эдийн экспортоос ихээхэн хамааралтай тул худалдааны голлох түнш орнуудын ТХЗ-2030-ын хүрээнд авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бодлогын алхмуудын нөлөөллийг судалж, дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогодоо тусгаж байх нь чухал юм.



Эх сурвалж: *Atlas of Economic Complexity (2019)*

Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтийг авч үзвэл, хөрш хоёр улс болох БНХАУ, ОХУ-тай нийт худалдааны 70 гаруй хувийг хийсэн бөгөөд 2021 оны эхний 4 сарын байдлаар 129 улстай 4.5 тэрбум ам.долларын худалдаа хийснээс БНХАУ-тай 3.1 тэрбум долларын буюу нийт дүнгийн 68.7 хувьтай тэнцэх хэмжээний худалдаа хийсэн байна [2].

БНХАУ: Монгол Улсын нүүрсний экспорт нэг улсаас хараат байгаа учир БНХАУ-ын Парисын хэлцлийн дагуу авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээнээс Монгол Улсын экспортын орлого ихээхэн хамаарах боломжтойг харуулж байна. БНХАУ-ын 14 дүгээр 5 жилийн төлөвлөгөөнд нүүрстөрөгчийн ялгарлыг нэмэгдүүлэх үйлдвэрлэлийн төлөвлөгөөнүүд тусгагдсан байгаа нь тус улсын хувьд 2030 он хүртэл нүүрс болон бусад нүүрстөрөгчийн хий ялгаруулдаг түүхий эдийн хэрэглээ төдийлөн буурахгүй гэсэн төсөөллийг судлаачдын дунд үүсгэж байна. Харин БНХАУ-ын Ерөнхийлөгч Ши Жинь Пин 2020 оны 9 дүгээр сард Нэгдсэн Үндэсний Байгууллагын ерөнхий ассамблейн үеэр БНХАУ-ын нүүрстөрөгчийн хийн ялгаруулалт 2030 онд оргил түвшиндээ хүрч 2060 онд нүүрстөрөгчийн саармаг түвшин буюу “Цэвэр дүнгээр тэг” зорилтод хүрнэ гэж мэдэгджээ.

Монгол Улсын гадаад худалдааны голлох арван улс
(нийт эргэлтээр, 2020)

	Гадаад худалдаа хамаарал (2005-2020)			Дэлхийн нүүрсхүчлийн хий ялгаруулалт	
	Импорт	Экспорт	Нийт эргэлт	Эрэмбэ	Эзлэх хувь
1 БНХАУ	31.3%	83.5%	57.8%	1	27.9%
2 ОХУ	28.8%	1.6%	15.0%	4	4.6%
3 Япон	7.7%	0.3%	4.0%	5	3.0%
4 БНСУ	5.8%	0.6%	3.2%	9	1.7%
5 АНУ	5.2%	0.9%	3.0%	2	14.5%
6 Их Британи	0.6%	4.7%	2.7%	18	1.0%
7 ХБНГУ	3.4%	0.4%	1.8%	7	1.9%
8 Швейцарь	0.3%	3.1%	1.7%	72	0.1%
9 Итали	0.8%	0.9%	0.9%	19	0.9%
10 Сингапур	0.9%	0.6%	0.7%	68	0.1%

Эх сурвалж: YCХ, Our World In Data, судлаачийн тооцоолол

ОХУ: ОХУ-ын үндэсний аудитын байгууллагаас ган, зуд зэрэг байгалийн онц ноцтой үзэгдлийн давтамж нэмэгдэж байгаа нь тус улсын ХАА-н салбарт сөргөөр нөлөөлж, 2030 он гэхэд ДНБ-ий 2-3 хувьд хүрч болзошгүй байгааг анхааруулсан байна. Түүнчлэн, 140 гаруй хотод нийт хүн амын 40 орчим хувь нь агаарын бохирдолд өртөж, жил бүр 3 мянган км.квадрат ой устаж байгаа ажээ [3]. 2035 он хүртэл хэрэгжүүлэхээр шинээр баталсан “Эрчим хүчний стратеги”-д сэргээгдэх эрчим хүчний салбараас илүүтэй шатах ашигт малтмал (fossil fuels)-ын дотоодын үйлдвэрлэл, хэрэглээг дэмжиж, байгалийн хийн экспортод голлон анхаарахаар тусгасан байна. Энэ нь ОХУ ойрын хугацаанд уур амьсгалын талаар тухайлсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх сонирхол бага байгааг харуулсан юм. Үүнтэй холбоотойгоор олон улсын шүүмжлэлд өртөөд байсан бол 2020 оны 11 сард 2030 он гэхэд ойн шингээх дээд хэмжээгээ харгалзан үзэж, нүүрстөрөгчийн хийг 1990 оны түвшнээс хамгийн багадаа 30 хувиар бууруулна гэсэн шинэ зорилтоо НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцод танилцууллаа. Энэхүү зорилт нь хүлэмжийн хийн ялгаруулалтын хувь хэмжээний хувьд өмнөх зорилтоос сайжруулсан боловч тус улсын хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахад хангалтгүй хэвээр байгаа юм. Мөн ОХУ-ын эдийн засгийн хөгжлийн яамнаас мэдээлснээр Үндэсний хөгжлийн стратеги 2050 баримт бичиг нь 2021 оны эцэс гэхэд боловсруулагдаж дуусах бөгөөд баримт бичигт тусгаснаар 2030 онд гэхэд нүүрстөрөгчийн хийг 33-36 хувь бууруулна гэсэн нь НҮБ-д танилцуулсан зорилтоос өндөр байгаа юм.

Япон: Парисын хэлэлцээрийн дагуу Япон Улс нүүрстөрөгчийн хийг 2013 оны түвшинтэй харьцуулахад 26 хувиар бууруулна гэж байсан бол шинэ Ерөнхий сайд Ёошихидэ Суга (Yoshihide Suga) тус түвшнийг 46 хувь, цаашлаад 50 хувь хүртэл бууруулахыг зорих болно гэдгээ мэдэгдсэн байна. Үүнтэй холбоотойгоор хэрэгжүүлж буй алхам нь “Үндэсний эрчим хүчний суурь төлөвлөгөө” (Basic Energy Plan)-г боловсруулж байгаа бөгөөд түүнд: (i) том хэмжээний, үр ашиг муутай нүүрсний цахилгаан станцыг хэрэглээнээс гаргах; (ii) зөвхөн урт хугацаанд нүүрстөрөгчийн хий ялгаруулахаа болихоор шийдсэн улс орнуудад нүүрсний цахилгаан станцын санхүүжилт олгох гэсэн хоёр чухал өөрчлөлтийг оруулжээ. Нүүрстөрөгчийн хийг 46 хувиар бууруулна гэдэг нь томоохон сорилт боловч Парисын хэлэлцээрийн амлалтын дагуу дэлхийн дулаарлын түвшинг 1.5 хэмээс хэтрүүлэхгүйн тулд Япон Улс 2013 оны түвшнээс 62 хувиар бууруулах шаардлагатай юм.

БНСУ: Ерөнхийлөгч Мүүн Жае Ин (Moon Jae-in) 2030 он гэхэд нүүрстөрөгчийн хийг бууруулж, цаашлаад 2050 онд нүүрсхүчлийн хийн хувьд саармаг улс болно гэж дээд хэмжээний уулзалтын үеэр мэдэгдсэн байна [4]. БНСУ нь 2030 онд нүүрстөрөгчийн хийг 2017 оны түвшнээс 24.4 хувиар бууруулахаар амласан байсан бол 40 хувь болгож шинэ зорилгоо дэвшүүлжээ. Дэлхийн хамгийн том, далай дээр хөвөгч салхины цахилгаан станц барихаар 32 тэрбум ам.доллар төлөвлөсөн нь 2050 онд тавьсан зорилгоо биелүүлэх гол түлхүүр гэж үзэж байгаа ажээ. Тус станц нь 5.7 сая өрхөд хүрэлцэхээр эрчим хүч үйлдвэрлэж, 210 мянган ажлын байр шинээр бий болгож, жил бүр 9.3 сая тонн нүүрстөрөгчийн хийг бууруулахын зэрэгцээ 84 мянган тонн цэвэр устөрөгч³ үйлдвэрлэх хүчин чадалтай юм [5].

АНУ: Нүүрстөрөгчийн ялгаруулдаг хэмжээгээр дэлхийд хоёрдугаарт эрэмбэлэгддэг АНУ нь Парисын хэлцлийн хүрээнд нүүрстөрөгчийн хийг 2030 он гэхэд 2005 оны түвшнээс 50-52 хувиар бууруулж, нийт хэмжээг 5-10 хувь бууруулах төлөвлөгөөгөө танилцуулжээ. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэх гол шийдлийг ерөнхийлөгч Жое Байдан (Joe Biden)-ны дэд бүтцийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө (The American Jobs Plan) гэж үзэж байна. 2 их наяд долларын өртөгтэй тус төлөвлөгөөнд нүүрстөрөгчгүй цахилгаан эрчим хүчний салбарыг бий болгохоор цахилгаан сүлжээ, нөхөн сэргээгдэх эрчим хүчний технологид 100 тэрбум доллар төсөвлөсөн бөгөөд одоогоор парламентаар дэмжигдэх эсэх нь эргэлзээтэй хэвээр байна [6].

Дэлхийн хүлэмжийн хийн дийлэнх хэсгийг БНХАУ, АНУ, Европын холбооны орнууд, ИБУИНВУ, Япон зэрэг хөгжингүй, аж үйлдвэрлэлд суурилсан эдийн засагтай улсууд бүрдүүлдэг. Харин тус улс орнууд Парисын хэлэлцээрийн дагуу 2030 он гэхэд хүлэмжийн хийг бууруулах хувь хэмжээг шинэчлэн

³ Устөрөгч нь байгальд хамгийн элбэг байдаг бөгөөд маш жижиг, хөнгөн боловч эрчим хүчний хүчирхэг эх үүсвэрийн нэг юм.

тогтоож, дунд болон урт хугацааны стратегийн баримт бичигтээ тусгаж эхэлсэн. Тухайлбал, БНХАУ, Япон зэрэг орнууд хүлэмжийн хий ихээр ялгаруулдаг, үр ашиг муутай цахилгаан станцаа хэрэглээнээс халахаар төлөвлөөд байгаа бол БНСУ хилийн чанад дахь нүүрсний цахилгаан станцын санхүүжилтээ бүрмөсөн зогсоохоо мэдэгдээд байна.

5. Монгол Улсын анхаарах асуудлууд

Парисын хэлэлцээр Монгол Улсад яагаад чухал вэ? Монгол Улсын нийт экспортын орлогын 89.3 хувь (2010-2020 оны дундаж)-ийг уул уурхайн эрдэс баялгийн түүхий эд бүрдүүлдэг. Тэр дундаа чулуун нүүрсний экспорт энэ хугацаанд нийт экспортын орлогын 31.2 хувь буюу дунджаар 1.7 тэрбум ам.долларыг жил бүр дангаар бүрдүүлж ирсэн байна.

Тэгвэл дэлхийн нийт нүүрстөрөгчийн хийн хэмжээгээр тэнцүүлсэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгод дэлхийн томоохонаж үйлдвэржсэн эдийн засгууд нэгдэн XXI зууны төгсгөлд цэвэр дүнгээр тэг буюу Net-zero зорилгод нэгдээд байгаа нь цаашид дэлхийн аж үйлдвэрийн голлох түүхий эдийн хэрэглээ нүүрс, газрын тос, байгалийн хийнээс зайлсхийж сэргээгдэх эрчим хүч, цахилгаан эрчим хүч рүү шилжих суурь нөхцөлүүд бүрджээ. 2019 оны дүнгээр нийт нүүрстөрөгчийн хий ялгаралтын 39.4 хувийг нүүрс дангаар бүрдүүлж байна. Харин 2018 оны Дэлхийн банкны тооцооллоор 1000 тонн нүүрстөрөгчийн хийн ялгаралттай тэнцэх хүлэмжийн хий ялгаруулалтын хэмжээгээр БНХАУ дэлхийн нийт хүлэмжийн хий ялгаралтын 26.9 хувийг бүрдүүлж байгаа юм.

Монгол Улсын хувьд Тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд цаашид дотооддоо анхаарах асуудлуудын нэн тэргүүнд агаарын бохирдлыг авч үзсэн. Үүний зэрэгцээ ажилгүйдлийн түвшин өндөр хэвээр байгаа, ядуурлын эмзэг байдал өндөр байгаа, эдийн засгийн өсөлт тогтвортой бус байгаа зэрэг асуудал байна (Дэлгэрэнгүйг хүснэгт 3-аас харна уу).

- Манай орон уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн ихээр өртөж буй орнуудын нэг юм. Тухайлбал, өнгөрсөн 70 гаруй жилийн хугацаанд жилийн дундаж агаарын температур 2.24 хэмээр нэмэгдсэн нь дэлхийн дундаж өөрчлөлтөөс даруй гурав дахин их үзүүлэлт юм.
- Гурван хүн тутмын нэг нь ядуу буюу өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд ядуурлын түвшин 20 хувиас буураагүй нь ядуурал улам угжирч байгааг харуулж байна.
- Сүүлийн 30 гаруй жилд Улаанбаатар хотын гэр хороолол эрчимтэй хүрээгээ тэлж, түүнтэй холбоотой орчны бохирдол, гэмт хэрэг, хүчирхийлэл, үйлчилгээний хүртээмж зэрэг асуудал даамжирсаар байна.

- Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдийнхээс өндөр байгаа боловч ажиллах хүчний оролцооны түвшин, дундаж цалингийн хэмжээгээр эрэгтэйчүүд өндөр байгаа манай оронд хүйсийн тэгш бус байдал өндөр байгааг харуулах нэг үзүүлэлт юм.
- Манай орны төр засгийн тогтвортой байдал маш сул байна. Тухайлбал, өнгөрсөн 28 жилд Засгийн газар дунджаар 1.5 жил ажиллажээ.

Хүснэгт 3

Монгол Улсын ТХЗ-2030-ын биелэлт болон анхаарах асуудлууд

Зорилт	Биелэлт	Анхаарах асуудлууд
1. Ядуурлыг устгах	<ul style="list-style-type: none"> • Нийт хүүхдийн 88.9 хувь, ахмадын 97.5 хувь, ажилгүйчүүдийн 44.7 хувь нь нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд хамрагдсан. 	<ul style="list-style-type: none"> • Гурван хүн тутмын нэг нь ядуу ба ядуурлын түвшин 21.6 хувиас (2015) 29.6 хувь (2016) болж нэмэгдсэн.
2. Өлсгөлөнг зогсоох		<ul style="list-style-type: none"> • Бичил гэжээлийн дутал эмэгтэйчүүд, хүүхдийн дунд түгээмэл байна.
3. Эрүүл мэндийг дэмжих	<ul style="list-style-type: none"> • Дундаж наслалт 63.2-с (2000) 69.9 (2017) болж өссөн. • 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 25.6-с 16.7 болж буурсан. 	<ul style="list-style-type: none"> • Эхийн эндэгдэл хөдөө орон нутагт өндөр хэвээр байна. • Сүрьеэ өвчний тархалт 15-34 насны залуучуудын дунд хамгийн өндөр байна.
4. Чанартай боловсролыг дэмжих	<ul style="list-style-type: none"> • Нийт хүн амын 98 хувь нь бичиг үсэгт тайлагдсан. • Нийт сургуулийн 96 хувь нь цахилгаан ЭХ, 95 хувь нь компьютер ашиглаж, 68 хувь нь интернэтэд холбогдсон. 	<ul style="list-style-type: none"> • 6-14 насны 682 хүүхэд сургууль завсардсан. • Боловсрол эзэмшсэн залуучууд хөдөлмөрийн зах зээл дээрээс ажил олж чадахгүй байна.
5. Жендерийн эрх, тэгш байдлыг хангах	<ul style="list-style-type: none"> • Монголын эмэгтэйчүүдийн ХХИ 0.750 болж эрэгтэйчүүдийнхээс (0.733) өндөр болсон. 	<ul style="list-style-type: none"> • Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс өндөр боловсролтой хэдий ч АХОТ, дундаж цалингийн хэмжээгээр бага байна.
6. Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах		<ul style="list-style-type: none"> • Нийт хүн амын 46.2 хувь нь амьдардаг Туул голын сав газрын экосистем доройтож байна.
7. Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх	<ul style="list-style-type: none"> • Цахилгааны шөнийн тарифыг 2016.11 сараас 50 хувь, 2017.1 сараас 100 хувь хөнгөлсөн. 	<ul style="list-style-type: none"> • Цахилгаан эрчих хүчний 21 хувь нь импортоос хараат (2017) бөгөөд сэргээгдэх эрчих хүний эх үүсвэр 4.3 хувь.

8.	Эдийн засгийн өсөлт, ажлын байрыг бий болгох	<ul style="list-style-type: none"> Эдийн засаг өсөлт 2017 онд 5.3 хувь, 2018 онд 6.9 хувь болж өссөн. Интернэт ашиглалт: нийт иргэдийн 94 хувь 	<ul style="list-style-type: none"> Залуучуудын ажилгүйдлийн түвшин улсын дунджаас 3 дахин өндөр. Нэг салбараас хэт хамааралтай буюу ачаа тээврийн 57.8 хувь, зорчигч тээврийн 98.4 хувийг авто тээвэр гүйцэтгэж байна.
9.	Инновац болон дэд бүтцийн нэмэгдүүлэх		
10.	Тэгш бус байдлыг бууруулах		<ul style="list-style-type: none"> Жини коэффициент Улаанбаатар хотод хамгийн өндөр 0.34, аймгийн төвүүдэд 0.30 - 0.32 (2016) байна.
11.	Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	<ul style="list-style-type: none"> УБ хот: ДНБ-ий 64.7 хувийг үйлдвэрлэдэг 	<ul style="list-style-type: none"> Нийслэлийн нийт өрхийн 57 хувь нь гэр хороололд амьдардаг. Улам бүр нэмэгдэж буй хог хаягдлын 10 хүрэхгүй хувийг дахин боловсруулж байна.
12.	Хариуцлагатай хэрэглээ		
13.	Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах	<ul style="list-style-type: none"> Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 13.8 хувь (2000)-иас 17.85 хувь (2018) болж нэмэгдсэн. 	<ul style="list-style-type: none"> Гамшигт үзэгдлийн давтамж цаашид улам бүр эрчимжих төлөвтэй байна. Нэг хүнд ногдох хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ өндөр буюу дэлхийн дунджаас 2.7 дахин их байна.
16.	Энх тайван, шударга ёсыг цогцлоох	<ul style="list-style-type: none"> Авлигын үзүүлэлт: 2017 (180 орноос 103-т), 2018 (180 орноос 93-т) 	<ul style="list-style-type: none"> Гэмт хэрэг нэмэгдэж, хохирсон хүмүүсийн 27 хувь нь эмэгтэй, 6 хувь нь хүүхэд, 5 хувь нь нас барсан. Засгийн газрын ажилласан дундаж хугацаа 1.5 жил.
17.	Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> Бизнес эрхлэхэд хялбар: 2017 онд 190 орноос 62-т эрэмбэлэгдэв. 	

Эх сурвалж: Монгол Улсын үндэсний сайн дурын илтгэл (2019)

6. Дүгнэлт

Монгол Улс Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг 2020 онд УИХ-аар батлуулснаар 2016 оны Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 бодлогын баримт бичиг хүчин төгөлдөр бус болжээ. Одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Алсын хараа 2050 бодлогын баримт бичиг нь НҮБ-ээс баталсан ТХЗ-2030-тай холбоотой урт хугацааны нийгэм, эдийн засгийн зорилтоос гадна Монгол Улсын хөгжлийн бусад асуудлыг багтаасан илүү өргөн цар хүрээтэй төлөвлөгөө болсон. Одоогоор энэхүү бодлогын баримт бичгийн биелэлттэй холбоотой албан ёсны тайлан, статистик гарч эхлээгүй байгаа хэдий

ч Монгол Улс “Үндэсний сайн дурын илтгэл”-ээр дамжуулан ТХЗ-2030-ийн хэрэгжилтийг тайлагнаж байна.

2019 оны тайланд Монгол Улсын хувьд Тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд цаашид дотоодод анхаарах асуудлын нэн тэргүүнд агаарын бохирдлыг авч үзжээ. Үүний зэрэгцээ ажилгүйдлийн түвшин өндөр хэвээр байгаа, ядуурлын эмзэг байдал өндөр байгаа, эдийн засгийн өсөлт тогтвортой бус байгаа зэрэг бусад анхаарах асуудал байгаа юм.

Дэлхийн улс орнууд Тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд, НҮБ-ээс дэвшүүлээд буй нэн тэргүүний зорилт болох уур амьсгалын өөрчлөлтийг тогтворжуулах, Парисын хэлэлцээрийн хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зэрэг дэлхийд тулгамдаад буй байгаль орчин, нийгэм эдийн засгийн асуудалтай уялдуулан эрчимтэй алхмыг хэрэгжүүлж эхэлснээр үйлдвэрлэлд ашиглагдаж буй голлох түүхий эд, эрдэс бүтээгдэхүүний эрэлт, хэрэгцээ дараагийн 50 жилд асар хурдацтай өөрчлөгдөх хүлээлттэй байна.

Шатах ашигт малтмал, тэр дундаа чулуун нүүрс, газрын тос зэрэг нь Монгол Улсын экспортод голлох дүнг эзэлдэг. Манай орны худалдааны гол түнш болох БНХАУ-ын хувьд ТХЗ-2030-ийн хүрээнд 2020 онд хийсэн мэдэгдэлдээ 2030 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөөнд нүүрстөрөгчийн хий ялгаруулалт өндөр түвшинд хэвээр байх бөгөөд 2060 он гэхэд цэвэр дүнгээр тэг зорилтод хүрэхээр төлөвлөж байгаагаа дурдсан билээ.

Монгол Улс эдийн засгийн гол түнш орнуудын хэрэгжүүлэх бодлогын алхамтай уялдуулан урт хугацааны хөгжлийн бодлогоо цаг тухай бүрт нь сайжруулж, Алсын хараа 2050 баримт бичигт дурдагдсан заалтыг цаг хугацааны хувьд нарийн төлөвлөх, дэд зорилтын хэрэгжилтийг харуулсан нэгдсэн тайланг боловсруулах зэрэг асуудал чухал юм.

Ном зүй:

- [1] Монгол Улсын Засгийн газар, “Монгол Улсын үндэсний сайн дурын илтгэл,” Улаанбаатар, 2019.
- [2] M. Unurzul, “Mongolia trades with 129 countries,” 17 5 2021. [Online]. Available: <https://montsame.mn/en/read/264154#:~:text=Mongolia%20trades%20with%20129%20countries>.
- [3] J. Cordell, “Climate Change Threatens Russia’s Economic Growth, Watchdog Warns,” 14 1 2020. [Online]. Available: <https://www.themoscowtimes.com/2020/01/14/climate-change-threatens-russias-economic-growth-watchdog-warns-a68878>.
- [4] N. Hyun-woo, “Korea to unveil higher target of carbon emissions reduction in Nov,” 31 5 2021. [Online]. Available: https://www.koreatimes.co.kr/www/nation/2021/06/371_309663.html.
- [5] P. Chan-kyong, “South Korea will spend US\$32 billion on world’s largest floating offshore wind farm,” 7 5 2021. [Online]. Available: <https://www.scmp.com/week-asia/health-environment/article/3132563/south-korea-will-spend-us32-billion-worlds-largest>.
- [6] The White House, “FACT SHEET: The American Jobs Plan,” 31 3 2021. [Online]. Available: <https://www.whitehouse.gov/briefing-room/state-ments-releases/2021/03/31/fact-sheet-the-american-jobs-plan/>.
- [7] Монгол Улсын Засгийн газар. Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020.
- [8] ҮСХ. Тогтвортой хөгжлийн зорилго 2030, 2016.
- [9] Монгол Улсын Их Хурал. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, 2016.
- [10] Монгол Улсын Их Хурал. Ногоон хөгжлийн бодлого, 2014.
- [11] United Nations, “undp.org,” 2015. [Online]. Available: [https://www.undp.org/sustainable-development-goals#:~:text=The%20Sustainable%20Development%20Goals%20\(SDGs\)%2C%20also%20known%20as%20the,people%20enjoy%20peace%20and%20prosperity..](https://www.undp.org/sustainable-development-goals#:~:text=The%20Sustainable%20Development%20Goals%20(SDGs)%2C%20also%20known%20as%20the,people%20enjoy%20peace%20and%20prosperity..)
- [12] U. N. The Energy Progress Report, “trackingsdg7.esmap.org,” 2015. [Online]. Available: <https://trackingsdg7.esmap.org/>.
- [13] T. W. B. World Development Indicators, “<https://databank.worldbank.org/home.aspx>,” 2021. [Online]. Available: <https://databank.worldbank.org/source/world-development-indicators>. [Accessed 2021].